



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/228

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дахь хэсгийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний сайд Н.Тавинбэх аймагт ажиллах зардалд 6,837,800 төгрөг, аймгийн Засаг дарга Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станцын Баян-Өлгий аймгийн нөлөөллийн бүсийн айл өрхүүдтэй уулзалт зохион байгуулсан зардалд 376,110 төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтнууд Баянхонгор, Өвөрхангай аймгуудаас туршлага судлах зардалд 246,005 төгрөг, Шинэ жилийн арга хэмжээний Засаг даргын гарын бэлэгний зардалд 4,010,000 төгрөг, аймгийн Засаг дарга Зүүн бүсийн сумдад ажилласан зардалд 462,600 төгрөг, Ерөнхий сайд Баян-Өлгий аймагт ажиллах үед аймгийн Засаг дарга очиж ажилласан зардалд 1,663,400 төгрөгийг тус тус баталж зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 13,595,915 төгрөг (арван гурван сая таван зуун ерөн таван мянга есөн зуун арван тав)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

7400 01 1117  
Zah A/228 Kh